

Badmaavanchin Munguntsetseg

МОНГОЛ ХЭЛНИЙ ҮЙЛЭЭС НЭР ҮГ БҮТЭЭХ

“Ц” ДАГАВРЫН УТГЫН АСУУДАЛД

In the issue of meaning of Mongolian suffix “-ц”, forms noun from verb

Б. Мөнгөнцэцэг³³

Монгол хэлний үгсийг бүтээгч утга бүхий хэсэг нь өөр хоорондоо нягт холбогдож утгын хувьд шүтэн барилдаж байж сая цогц нэгэн утгыг үгээр дамжуулан хүний оюун, сэрэл сэтгэхүйд хүргэдэг бөгөөд “үгийн дагавар нь язгуураасаа ангид ямар ч утга илтгэсэн дохио болж чадахгүй, үүнчлэн үгийн цэвэр язгуур нь дагавраасаа ангид тодорхой утгатай дохио болж чадахгүй юм³⁴”. Энэхүү “...тогтсон байрлал, дарааллын дагуу бүтээврүүд өөр хоорондоо шүтэн барилдаж, утга дамжилсан байдалтай болж, язгуур бүтээвэр хамгийн ерөнхий утгыг хадгалж, дагавар, нөхцөлийн илэрхийлэх утгаар улам тодорхой, илүү хийсвэр болдог байна”³⁵

Бид монгол хэлнээ түгээмэл хэрэглэгддэг бүтээлч дагаврын нэг болох үйл үгээс нэр үг үүсгэдэг “-ц” дагаврын салаа утгыг тодорхойлохдоо тухайн үндэс язгуурын утгаас хэрхэн шалтгааж байгаагаар нь ялган авч үзлээ.

Уг дагаврын утгыг монгол хэл зүйн судалгааны зарим бүтээлд хэрхэн тодорхойлсныг үзье.

	утга Эрдэмтдийн нэр	Үйлийн үр дүн	Үйлийн орших байр, орон	Үйлийг эдлэгч, гүйцэтгэгч, эзэн	явц, үйлийн байдал	Үйлээр үүссэн юм	Үйлд өртөх, холбогдох, хэрэглэгдэх	Буй нь болж үйлээр нэрлэнэ	Бүтээлч үйл	Хийсвэр утга	хир үйлийн хэмжээ	чанар шинж заасан
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1.	Бадамдорж Д. ³⁶	+										
2.	Бертагаев Т. А. ³⁷	+	+	+	+	+				+		
3.	Болд Л. ³⁸	+	+		+		+			+		
4.	Бямбасан П. ³⁹	+	+	+								
5.	ОЦМХЗүй ⁴⁰	+	+	+		+						
6.	Цэнгэлтэй ⁴¹	+	+				+					

³³ Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхимийн багш, доктор (Ph.D)

³⁴ Лувсанвандан Ш. Орчин цагийн монгол хэлний бүтэц. Монгол хэлний үг, нөхцөл хоёр нь, Уб., 1968, 101

³⁵ Бадамдорж Д. Орчин цагийн монгол хэлний утга судлалын үндэс, Уб., 1997, 146

³⁶ Бадамдорж Д. Дурдсан зохиол, Уб., 1997, 146

³⁷ Бертагаев Т.А. Лексика современных монгольских литературных языков. М., 1974, 198-199

³⁸ Болд Л. Орчин цагийн монгол хэлний дагавар, Уб., 1986, 39

³⁹ Бямбасан П. Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц- нэр үгсийн аймаг, Уб., 1975, 32

⁴⁰ Орчин цагийн монгол хэлний зүй, Уб., 1966, 82

⁴¹ Цэнгэлтэй. Одоо үеийн монгол хэлний зүй, Хөх хот, 1984, 547

7.	Кондрашов А. Н. ⁴²	+										
8.	Цэцэнцогт Ш. ⁴³		+			+	+					
9.	Сэцэн ⁴⁴	+				+					+	+
10.	Хайрхан ⁴⁵										+	+
11.	Хас Эрдэнэ, Наранбат ⁴⁶		+		+							
12.	Поппе Н. ⁴⁷			+		+	+					
13.	Лувсанвандан Ш. 48	+	+	+		+						
14.	Руднев А. Д. ⁴⁹						+					
15.	Орловская М. Н. ⁵⁰	+	+		+			+				
16.	Дондуков У-Ж. Ш. 51	+	+	+		+			+			
17.	Тэгшдүүрэн ⁵²		+		+	+					+	

Энэ тухайд эрдэмтэн М. Базаррагчаа “Энэхүү “-са...” үе-утгалбар нь нэр ба үйл болон хөрвөх ба тэдгээрийн салаа утга нь тухайн үндэс язгуурын утгаас ихээхэн шалтгаах тул яг таг зааглах нь төвөгтэй юм. “-са...” үе-утгалбар нь “зүг зүгт тархах” ба “зүг зүгээс хуралдах” гэсэн утгатай тул нэр бүтээх “-са...” нь уг үйлийн дагуу бүтсэн юмын цар хүрээ буюу эрдэмтдийн өгүүлснээр, хэмжээ хүрээ, явц боломж, янз байдлыг заасан утгатай...”⁵³ гэжээ.

Үйл үгээс нэр үг үүсгэх “-ц” дагаврын утгыг нэг талаас, бодит юм үзэгдэлтэй шууд холбоо бүхий юмжуулах харьцаа (денотативное отношение), нөгөө талаас, юм үзэгдэлтэй шууд холбоогүй, харин юмын шинж чанар, хөдөлгөөнтэй холбоотой дохиожуулах харьцаа (сигнификативное отношение)-ны үүднээс ялган үзэж болмоор байна. Үүнд:

⁴² Кондрашов А.Н. К вопросу об образовании социально- экономической терминологии Монгольского языка, МХШ, боть V (XXVII), 7-р дэвтэр, Уб., 1999, 92

⁴³ Цэцэнцогт Ш. Монгол үгсийн язгуурын толь, Жанг Жияа Кеу, 1988, 2810

⁴⁴ Сэцэн. Одоо үеийн монгол бичгийн хэлний үг бүтээх дагаврын судлал, Хөх хот, 2004, 249, 279

⁴⁵ Хайрхан. Монгол хэлний үг бүтээх ёсны судлал, Хөх хот, 1998, 212-213

⁴⁶ Хас Эрдэнэ, Наранбат. Монгол хэлний үндэс, Хянган, 1978, 136

⁴⁷ Поппе Н. Грамматика письменно- монгольского языка, М., 1937, 98

⁴⁸ Лувсанвандан Ш. нар. “Жинхэнэ нэр...” Орчин цагийн монгол хэл, Уб., 1966, 82

⁴⁹ Руднев А.Д. Лекции по грамматике монгольского письменного языка, Санкт Петербург, 1905, 56


⁵⁰ Орловская М.Н. “Имя существительное”, (Грамматика бурятского языка, Фонетика и морфология), М., 1962, 62. Тэрээр, 1. Үйлийн үр дүн, явц заана. (alqu-са, dalāyi-са, oгу-са, qarāyi-са, qoli-са, ködel-се), 2. Тодорхой үйлийн төгс байдал, түүний хийсвэр шинжийг заана (bayta-са, бүтүгэ-се, oruldu-са, keregle-се) 3. Болж буй үйлээр нь нэрлэнэ (ēayilа-са, ebgū-се, qadqu-са), 4. Үйлийн орон заана (bayū-са, үг-са, čub-са, qonu-са) гэжээ.

⁵¹ У.-ж. Ш. Дондуков. Аффиксальное словообразование частей речи в бурятском языке. Улан-Удэ., 1964, стр. 35-36, 55. Тэрээр, а). үйлийн утга дагуух үйлдэгч эзэн (зарц), б). үйлийн утга дагуух юм, хэрэглэл (өлгөц, цайлгац), в). Үйлийн үр дүн (хольц), г). үйлийн хийсвэр үр дүн (гутац, нууц), д). Үйлийн орон (бууц), е). Бүтээлч үйл (бүтээц) гэж ялгасан байна.

⁵² Тэгшдүүрэн. Монгол хэлний үг бүтэх ёсны судлал. Лиоунинг, 2005, 44, 64-65

⁵³ Базаррагчаа М. “-са...” үе-утгалбарын утга, гарал, тархац, Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, МУИС., 30-р боть, (318), Уб., 2009, 19

I. юмжуулах буюу бодит харьцаа II. дохиожуулах буюу хийсвэр харьцаа



Одоо уг дагавраар илрэх утга нь чухам ямар үндсэнд залгаснаас хамаарч өөр өөр байгааг харьцуулан авч үзье.

1. а. *Нэр үг үүсгэх “-ц” дагавраар хэрэглүүрийн утга илрэх нь:*

Өөрийн эрхээр хөдлөх утгатай:	
хаа- (3. явах, хөдлөх, урсах хөдөлгөөнийг зогсоох, 4. халхлах) →	хаац (1. гол горхи зэргийн усыг боож хагасан хаалт, 2. хааж нөмөрлөсөн зүйл)
түш- (1. юманд түлж налах, хажуулах, 2. хазайсан буюу тогтоц муутай зүйлийг түлж тогтоох, дэмнэх, тэтгэх) →	түшиц (түшиг болох юм, түшиг тулгуур, тус дэм болсон юм)
гишгэ- (1. юмыг хөлийн улаар дарах, 2. алхах) →	гишгэц (гүехэн ус, шавар шалбаагтай газарт алхам тутамд тохируулан тавьсан чулуу)
дэлгэ- (2. олон юмыг тараан байрлуулж тавих) →	дэлгэц (дээр нь юм дэлгэх, тараан тавих хэрэгсэл)
боо- (4. халхлах, таглах, 7. хориг саад хийх, хяхах хавчих, үнэрхэх, гацах, 8. хаах, саатуулах) →	бооц (1. ус хаах хаалт, далан хаалт, 2. бусдын довтолгооны эсрэг тавьсан хориг, саад бэхлэлт)
Бүтээлгүй хөдлөх утгатай:	
орхи- (1. үлдээх, хоцроох, 2. хаях, гээх) →	орхиц (1. бараа нэхэхэд ширхгийг хэрээдэслэн элтэлж хөндлөн орхин нэхэх хэрэгсэл, 2. орхиж шидэх үйлийн хүчдэл)

б. *Нэр үг үүсгэх “-ц” дагавраар орны утга илрэх нь:*

Өөрийн эрхээр хөдлөх утгатай:	
суу- (бөгсөөрөө юман дээр түлж байх) →	сууц (байр, оршин суух байр, газар)
нуу- (бусдад мэдэгдэж харагдахгүйгээр дарж далдлах) →	нууц (биеэ далдлах газар)
гар- (б. гатлах, нэвтрэх, алгасаж өнгөрөх) →	гарц (гарах газар, гарам)

ор- (хүн, амьтан, юмны гадна талаас дотогшилох, ил байдлаас далд болох) →	орц (1. томоохон байшин, сууц дахь нийтийн эзэмшлийн газар, коридор хаалга, 2. оромж)
Ориих утгатай:	
багт- (юмны дотор орох, оролцох) →	багтац (багтах зай, багтах боломж)
буу- (5. түр болон удаан хугацаагаар ориих, нутаглах) →	бууц (нутаглаж, буудаллаж байсан газар, гэр хотын ором)
Бүтээн хөдлөх утгатай:	
бул- (шороо зэрэг үйрмэг юм дээрээс нь асгаж битүүлж хучих, дарах) →	булац (хуучир. юм хадгалах газар)

в. Нэр үг үүсгэх “-ц” дагавраар үйл гүйцэтгэгчийг заасан утга илрэх нь:

Бүтээлгүй хөдлөх утгатай:	
зар- (ямар нэгэн үйл ажлыг бусдаар албадан хийлгэх, зарцлах) →	зарц (бусдын эрхшээл нөлөөний дор захирагдан зарцлагдах хүн)
хоно- (шөнийг өнгөрөөх, нөхцөөх) →	хоноц (гаднаас ирж хоносон хүн)
дар- (юмыг доош болгохоор хүчдэх) →	дарц (физик. Биеийн нэгэн талбай дээр эгцээр даран үйлчилж байгаа хүч)

г. Нэр үг үүсгэх “-ц” дагавраар уг үйлээр бүтсэн юмыг заасан утга илрэх нь:

Өөрийн эрхээр шилжсэн хөдлөх утгатай:	
цув- (хүн, амьтны ар араасаа дагаж явах) →	цувц (хүн, мал, амьтны цувж явдаг нарийн жим)
Бүтээн хөдлөх утгатай:	
нөө- (дараа хэрэглэхээр хадгалах, нөөцлөн үлдээх) →	нөөц (чухал хэрэгцээтэй цаг үед хэрэглэхээр хураан хадгалсан зүйл)
малт- (газар хонхойлж ухах) →	малтац (малтаж гаргасан юм)
тарь- (ургамал буюу ургамлын үрийг ургуулахаар хөрсөнд суулгах, булах) →	тарьц (тарьсан юм)
товхи- (цаас, бичиг мэтийг давхарлан үдэх, дэвтэр болгох, дэвтэрлэх) →	товхиц (товхимол, бяцхан танилцуулга)
торго- (гэм буруутай үйлдэл хийсэн хүнд шийтгэл болгож мөнгө төгрөг, эд зүйл авах) →	торгоц (торгууль)
Бүтээлгүй хөдлөх утгатай:	
бэлд- (бэлэн зэлэн болгох, төхөөрөх, зэхэх) →	бэлдэц (бэлтгэж, боловсруулж хийсэн зүйл, бэлдсэн юм, бэлэн юм)

2. а. Нэр үг үүсгэх “-ц” дагавраар янз байдал заасан утга илрэх нь:

Өөрийн эрхээр хөдлөх утгатай:	
гишгэ- (2. алхах) →	гишгэц (гишгэдэл)
буур- (доошлох, нам болох) →	буурц (буурах явц)

гарга- (4. бичиг баримт үйлдэх, 8. бичиг үсэг унших, бичиг мэдэх) →	гаргац (аливаа бичгийг уншихад ямар үсгээр юу гэдэг үгийг тэмдэглэсэн нь мэдэгдэх, танигдах бололцоо)
давхи- (1. мал, адгуус дөрвөн хөлөөрөө үзээд зэргээр хурдан харайлан явах, харайлгах, довтолох, 2. машин, галт тэрэг зэргийн хурдлан явах) →	давхиц (давхих хурдац)
дага- (юмны хойноос бараадан ойрхон явах, хамт байх) →	дагац (дагах шинж, дагах чанар, дагах байдал)
дөх- (4. ахих, дээшлэх, урагшлах) →	дөхөц (ахиц: ахиц дөхөц (дэвжис дээшлэх))
ир- (алив юм тэндээс энд болох, нааших, ямар нэг юм энд хүрэх) →	ирц (аливаа ажил үйлсэд хүмүүсийн ирсэн дүн бүртгэл)
нийл- (1. нэгдэн хамтрах, холилдох, 2. зохицох, таарч тохирох) →	нийлц (өөр хоорондоо нийлэх, авцалдах чанар)
сэлгэ- (сэлэх, солих, ээлжлэх) →	сэлгэц (сэлгэх явц, сэлгэх нь)
тул- (1. тулгуур болгох, түших, баганадах, 2. тулгуур хийх) →	тулц (тулсан байдал)
түлх- (юмыг гараар болон багаж хэрэгслээр хүчлэн цааш болгох, түрэх) →	түлхэц (1. түлхэх хүч, 2. түлхэлт)
хэр- (юмыг утас, дээс мэтээр хөндлөн гулд ороох, шидмэглэн оёх)	хэрц (хэрсэн байдал, хэрээс)
яв- (хүн, амьтны алхах, зорчих, одох) →	явц (ажил үйлийн бүтэмж, хийгдэх байдал)
хүлээ- (хүний хүрч ирэх, юмны болох цагийг харж суух, саатах, хүлээлзэх) →	хүлээц (юманд тайван, уужуу, тэвчээртэй хандах байдал)
барь- (аливаа юмыг гартаа атгах, хөтлөх) →	барьц (бөхийн барих газар)
Өөрийн эрхгүй хөдлөх утгатай:	
наалд- (1. юманд нягт барьцалдан тогтох, 2. юманд шахаж тулж барих, түших) →	наалдац (1. наалдах чанар, 2. наалдаж хоцрох зүйл)
төр- (шилж. өсөх, үржих, нэмэгдэх) →	төрц (1. өсөлт, хөгжилт, 2. төрж үржих чадвар)
хайл- (бодос, эрдэс махбод халууны илчинд шингэн болох, мөн тэдгээрийг халууны илчээр шингэн болгох) →	хайлц (юмны хайлах чанар, хайлах явц)
төгс- (1. юмны барагдаж дуусах, 2. ажил үйл эцэслэх) →	төгсөц (төгсвөр, төгсөх явц)
уус- (юм шингэн бодосын дотор орж хайлан шингэх) →	уусац (уусах хэмжээ, ууссан байдал)
урс- (ус зэрэг шингэн зүйлийн нүүн шилжих) →	урсац (урсах хэмжээ, урсах байдал)
Орших утгатай:	
бай- (орших, тогтнох, суух) →	байц (байр байдал, шинж төлөв)
орш- (1. амьдран суух, 2. байх, буй ахуй) →	оршиц (орших байдал, хэмжээ)

тогт- (ориших, хөдөлбөргүй болох) →	тогтоц (1. бүрэлдэн цогцолсон хэв маяг, төрх, 2. бүрэлдэн цогцлох явц)
зогс- (хүн, амьтны хөл дээрээ босоо байх) →	зогсоц (1. түр зогсох агишин, 2. хүн, амьтны зогсож буй байдал, зогсолт)
Бүтээн хөдлөх утгатай:	
ав- (аливаа юмыг өөрийн болгох, эзэмших) →	авц (үг хэл, үйл хэргийн нийлэмж, өгөөж)
илтгэ- (үзэл санаа, учир явдлаа үг яриа, үсэг бичиг, үйл хөдөлгөөнөөр илэрхийлэх, мэдэгдэх) →	илтгэц (илтгэн харуулж буй юм)
оно- (харвасан, шидсэн, буудсан сүм, чулуу онилсон газраа яг тусах, таарах) →	оноц (харваж, шидсэн зүйл байндаа туссан нь)
сонго- (сайныг шилэх, өөрт хэрэгтэй ашигтайг нь олж авах) →	сонгоц (шилц)
сур- (ямар нэгэн мэдлэг, заншлыг эзэмших, мэдэхгүй чадахгүй зүйлээ мэддэг чаддаг болох) →	сурц (сурах үйлийн явц, сурлага)
суулга- (9. ургамал, ногоог тарих) →	суулгац (суулгасан байдал)
хий- (үйлдэх, бүтээх) →	хийц (хийсэн янз маяг, үзэмж, чанар байдал)
холбо- (юмыг хооронд нь салахгүй болгон уях, торгох) →	холбоц (холбосон байдал)
холь- (юмыг нийлүүлж хутгах) →	хольц (юманд орсон орц, холио)
шах- (юмыг ойртуулан бөөгнөрүүлж нягт, чигжүү болгох) →	шахац (няг, нягтрал, нягтарсан байдал)
бүтээ- (аливаа зүйлийг бэлэн болгох, биелүүлэх, байгуулах, гүйцээх) →	бүтээц (юмыг бүтээх үйлийн нэр)
ойлго- (юмс үзэгдлийн учир шалтгаан, зүй тогтлыг ухамсарлан мэдэх) →	ойлгоц (үзэгдэл юмсын зүй тогтлыг ухааж мэдэх чадвар, хэмжээ)
олд- (алдсан гээсэн, хайлж хүсэж байсан зүйл нь тохиолдох) →	олдоц (олдох боломж, байдал)
сэтгэ- (ургуулан бодох, санаачлан бодох, тунгаан бодох) →	сэтгэц (сэтгэн бодох явц, сэтгэн бодох чадвар)
тарь- (ургамал буюу ургамлын үрийг ургуулахаар хөрсөнд суулгах, булах) →	тарыц (тарих явц)
турш- (1. уг санаа, хүч чадлыг нь сорих, 2. туршилага хийх) →	туршиц (туршилт)
торго- (юмыг түр зуур тогтоох, бөх бат биш бэхлэх) →	торгоц (торгож оёсон нь)
Бүтээлгүй хөдлөх утгатай:	
ахь- (1. нэмэгдэх, 2. урагилах, дөхөх, давших, 4. дэвших, дээшлэх) →	ахиц (ахих явц, урагштай байдал)
бүт- (1. төрөх, үүдэх, болох, биелэх, 2. боловсрох, гүйцэх) →	бүтэц (1. бодос юмсын дотоод бүрэлдэхүүний байгуулалт, 2. бүрдэл)
нух- (буталж нарийн ширхэгтэй болгох) →	нухац (нухсан байдал)

Тусган хөдлөх утгатай:	
хар- (нүдээр үзэх) →	харц (нүдний харах байдал)

б. Нэр үг үүсгэх “-ц” дагавраар хэмжээ заасан утга илрэх нь:

Өөрийн эрхээр хөдлөх утгатай:	
ор- (2. алив нэгэн юм руу чиглэн одоож дотор нь байх) →	орц (орох зүйл, орлого)
гар- (дотор, далд байсан юм гадагш шилжин байрлах, ил болох)	гарц (гарах хэмжээ)
өгс- (газрын өндөр тийш явах) →	өгсөц (өгсүүгийн хэмжээ)
шингэ- (1. ус, тос зэрэг юм, юманд нэвтрэн шингээж орох, 2. идсэн уусан юмны боловсрох)→	шингэц (шингэх явц байдал, хэмжээ, шингүүр, шингэвэр)
эргэ- (орчих, өнхрөх) →	эргэц (эргэх хэмжээ, эргэх хэм)
алх- (нэг нэгэн алхмаар урагшлан явах) →	алхац (алхах хэмжээ)
тус- (онох, тохиолдох) →	тусац (тусах хэмжээ)
тавь- (барьсан, уясан, бэхэлсэн юмыг сул чөлөөтэй болгох, тайлах, харвах) →	тавьц (юмыг түгээн тавих хэмжээ)
Өөрийн эрхгүй хөдлөх утгатай:	
уна- (18. шилж. ашиг олох, ашиг гаргах) →	унац (худалдаа наймааны ашиг орлого)
дуугар- (1. дуу чимээ гарах, 2. үг хэлэх, ярих) →	дуугарц (сонороор барагцаалсан дууны чанга сулын хэмжээ)
хат- (1. хуурай болох, ус чийггүй болох, 2. гол горхи ширгэх) →	хатац (хатах явц, хаталтын хэмжээ)
халд- (3. халдварлах, халдварлан өвдөх) →	халдац (халдах чанар, халдах хэмжээ)
тор- (тээглэх, тулгарах, саатах, бүдрэх) →	торц (торж тээглэх хэмжээ)
урга- (амьд юм, бие махбодын амьдран өсөх, томрох) →	ургац (1. нэгж талбайгаас хураан авах ургамлын хэмжээ, 2. өвс ногоо, ургамлын гарц)
ширгэ- (1. шингэн зүйлийн буцлах, халах зэргээс болж уур болон дэгдсээр үгүй болох, 2. малын сүү шим татрах, багасах, үгүй болох) →	ширгэц (ширгэх хувь хэмжээ)
Бүтээн хөдлөх утгатай:	
даа- (юмыг өөд нь өргөж чадах) →	даац (машин тэрэг, ачих зөөх хэрэгслийн даах чадал, ачаалах чадвар)
мэд- (1. хэрэг явдлын тухай үзэж сонссон танилцсан, мэдээтэй болсон байх, 2. юмс үзэгдэл, хэрэг явдлын тухай ухамсарлах, ойлгох) →	мэдэц (учир явдлын зүйг ойлгон мэдэх чадвар)
буд- (будаг түрхэх) →	будац (будах хэмжээ, будсан чанар)

дүй- (олон тооны юмыг худалдан авах, өгөхөд сайн муу их бага зэргийг тус тусад нь харгалзахгүй бөөнөөр үнэ тогтоож авах, өгөх) →	дүйц (дүйцүүлэх хэмжээс)
малт- (газар хонхойлж ухах) →	малтац (малтсан гүний хэмжээ)
нэмэгд- (олон болох, ихсэх) →	нэмэгдэц (1. нэмэгдсэн хэмжээ, 2. нэмсэн нь)
тат- (үгтээх, чангаах) →	татац (татах хүчний хэмжээ)
түрх- (юмыг жигд тараан наалдуулах, нялах) →	түрхэц (түрхсэн хэмжээ)
хүрт- (юмыг хуваахад ногдох хувь хүрэлцэх) →	хүртэц (хэрэгцээт юмны хэмжээ, ногдол)
Бүтээлгүй хөдлөх утгатай:	
атга- (юмыг гарынхаа хуруугаар хумин барих) →	атгац (атганд багтах хэмжээ)
булагд- (шороо зэрэг үйрмэг юманд хучигдан битүүрэх, дарагдах) →	булагдац (булагдсан юм, булагдаж байгаа хэмжээ, булагдаж байгаа эд баялаг)
далай- (юмыг занчих, цохих, цавчихыг завдан гар далайх болон зэвсэг өргөх) →	далайц (хэлбэлзлийн хуулиар өөрчлөгдөж байгаа хэмжигдэхүүн тэг утгаасаа хамгийн их хазайх хэмжээ)
илэр- (далд нууц юм ил болох, тодорхой болох) →	илэрц (хэрэг юмын илэрсэн хэмжээ; ил гарсан, ил тод болсон байдал)
сорь- (тэнсэх, турших) →	сорьц (2. ямар нэгэн зүйлийг шинжлэн туршихын тулд авч буй хэсэгхэн хувь, дээж)
таар- (1. юмны хэлбэр хэмжээ, амт шимт тохирох, 2. юмны сэтгэл санаанд тохирох, нийцэх) →	таарц (юмны таарах, тохирох хэмжээ)
тарх- (1. тархай бутархай байх, бие биенээсээ зайдуу орших, 2. цугласан нийлсэн хүн, амьтан таран явах, таран байрлах) →	тархац (1. тархсан хэмжээ, 2. тархалт)
тодор- (хэлбэр дүрс, бараа сураг нь бүдэг байсан зүйл тод болох) →	тодроц (тоддох хэмжээ, өнгөний ялгараа)
хэмнэ- (аливаа зүйлийг арвилах, гамнах) →	хэмнэц (хэмнэсэн хэмжээ, байдал)
үлд- (хэрэглэсэн юмнаас илүү гарах) →	үлдэц (үлдсэн хэмжээ, үлдсэн хэсэг)

Эцэст нь дүгнэхэд, монгол хэлний үйл үгээс нэр үг үүсгэдэг –ц дагаврын утга зүйн шинжийг авч үзэхэд уг дагаврыг залгахад илрэх утга нь холбогдож байгаа үгсийн үгийн сан- утга зүйтэй холбоо хамааралтай байна.

Бодит буюу юмжуулах харьцааны үүднээс, уг дагаврыг ихэвчлэн өөрийн эрхээр хөдлөх, бүтээн болон бүтээлгүй хөдлөх утга бүхий үйл үндсэнд залгахад юмыг зааж, улмаар үйлийн болох орон, хэрэглүүр, үйл гүйцэтгэгч, үйлээр бүтсэн юмыг заасан утга

цөөн боловч илэрч байна. Харин хийсвэр буюу дохиожуулах харьцааны үүднээс, юмыг заагаагүй бол янз байдал, хэмжээ заасан утга илтгэх нь олонтоо байна.

НОМЗҮЙ

- М. Базаррагчаа. “-са...” үе-утгалбарын утга, гарал, тархац, Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, МУИС. , 30-р боть, (318), Уб. , 2009
- Д. Бадамдорж. Орчин цагийн монгол хэлний утга судлалын үндэс, Уб. , 1997
- Ж. Баянсан. Монгол хэлний нэгэн дагавар бүтээврийн утга зүйн аасуудалд// МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг, №3 (83), Уб. , 1983
- Т. А. Бертагаев. Лексика современных монгольских литературных языков. М. , 1974
- Л. Болд. Орчин цагийн монгол хэлний дагавар, Уб. , 1986
- П. Бямбасан. Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц- нэр үгсийн аймаг, Уб. , 1975
- У. -ж. Ш. Дондуков. Аффиксальное словообразование частей речи в бурятском языке. Улан-Удэ. , 1964
- А. Н. Кондрашов. К вопросу об образовании социально- экономической терминологии Монгольского языка, МХШ, боть V (XXVII), 7-р дэвтэр, Уб. , 1999
- Ш. Лувсанвандан нар. “Жинхэнэ нэр...” Орчин цагийн монгол хэлний зүй. Уб. , 1966
- Ш. Лувсанвандан. Орчин цагийн монгол хэлний бүтэц, Монгол хэлний үг, нөхцөл хоёр нь, Уб. , 1968
- Н. Поппе. Грамматика письменно- монгольского языка, М. , 1937
- М. Н. Орловская. “Имя существительное”, (Грамматика бурятского языка, Фонетика и морфология), М. , 1962
- А. Д. Руднев. Лекции по грамматике монгольского письменного языка, Санкт Петербург, 1905
- Сэцэн. Одоо үеийн монгол бичгийн хэлний үг бүтээх дагаврын судлал, Хөх хот, 2004
- Тэгшдүүрэн. Монгол хэлний үг бүтэх ёсны судлал. Лиюунинг, 2005
- Хайрхан. Монгол хэлний үг бүтээх ёсны судлал. Хөх хот, 1998
- Хас Эрдэнэ, Наранбат. Монгол хэлний үндэс, Хянган, 1978
- Цэнгэлтэй. Одоо үеийн монгол хэлний зүй, Хөх хот, 1984
- Ш. Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь, Жанг Жияа Кеү, 1988

SUMMARY

Considering the characteristic according to meaning of Mongolian suffix “-ц” forms the noun from the verb, the words can be related with the vocabulary and meaning of the words' meaning.

According to the factual relation, in most cases when using this suffix for actions in active form, it expresses the things' relation and the place which actions would be happened, object of the actions, subject of the actions, the meaning which has been created by the actions revealed fewer. While according to the abstract or sign relations, it expresses the mood or measurement in meaning if not in objective mood.